КРЕДИТ
ББСБ

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МАТЕРИАЛ - 2024




Хүчтэй. Хамтдаа.

# ХУРАЛ ЗАРЛАСАН ТУЗ-ИЙН ТОГТООЛ

АRD КРЕДИТ ББСБ

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 3 сарын 13-ны өдөр №2024/11 Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.9, 62.1.14 дэх заалт, 65 дугаар зүйлийн 65.1, 65.3, 65.4, 65.5, 65.6 дахь заалт, 67 дугаар зүйл, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам", Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 3 сарын 13-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Ард Кредит ББСБ" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид "Хурал" гэх)-ыг 2024 оны 4 дугаар сарын 25-ны өдрийн 11.00 цагт "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК-ийн байранд зарлан хуралдуулсугай.
2. Хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2024 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн дотор Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржид тус тус хүргүүлсүгэй.
3. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас, өдөр тутмын хоёроос доошгүй сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2024 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн дотор нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2024 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлсүгэй.
4. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 4 дүгээр сарын 05-ны өдрөөр тогтоосугай.
5. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, танилцуулга, саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2024 оны 3 дугаар сарын 23-ны өдөрт багтаан үнэт цаасны брокер, дилерийн компаниудад хүргүүлсүгэй.
6. Хурлын даргаар "Ард Кредит ББСБ" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга (Ч.Ганзориг)-ийг томилсугай.
7. Дараах нэр бүхий хүмүүсийг Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

   Хурал зохион байгуулах комиссын дарга:
   
   Гүйцэтгэх захирал Г.Сүхбаатар
   
   Хурал зохион байгуулах комиссын гишүүд:
   
   Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Мөнх-Од
   
   Санхүү эрхэлсэн захирал Д.Лхагва-Очир
   
   Ерөнхий нягтлан бодогч Х.Цэрэннадмид
   
   Маркетингийн ахлах менежер Б.Пүрэвдорж
   
   Бүтээгдэхүүний хөгжүүлэлтийн менежер Г.Хонгорзул
   
   Маркетинг борлуулалтын мэргэжилтэн Б.Бүжин
   
   Санхүүгийн шинжээч Ш.Пүрэвдорж
   
   Байгууллага хариуцсан мэргэжилтэн: Д.Туяацэцэг

8. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, саналын хуудасны загварыг хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг гуравдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус батлсугай.
9. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2024 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 18:00 цагаар тасалбар болгосугай.
10. Хувьцаа эзэмшигчдийг Хурлын материалтай танилцах нөхцөл, боломжийг бүрдүүлж ажиллахыг Хурал зохион байгуулах комиссын дарга (Г.Сүхбаатар)-т даалгасугай.
11. Хурлын Тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

    Тооллогын комиссын дарга: Ө.Бямбагэрэл (Ард секюритиз ҮЦК ХХК)
    
    Тооллогын комиссын гишүүн: Т.Батбаяр (Ард секюритиз ҮЦК ХХК)
    
    Тооллогын комиссын гишүүн: Ө.Март (Ард Кредит ББСБ ХК)

12. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хурлыг зарлан хуралдуулах, хурлын зар мэдээг хүргэх, хувьцаа эзэмшигчдийг шаардлагатай мэдээллээр хангаж ажиллахыг Хурал зохион байгуулах комиссын дарга (Г.Сүхбаатар)-д даалгасугай.
13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлэхийг хурлын дарга (Ч.Ганзориг) болон Хурал зохион байгуулах комиссын дарга (Г.Сүхбаатар) нарт даалгасугай.

ДАРГА Ч.ГАНЗОРИГ

1. **Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах**

2. **Компанийн 2023 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах**

3. **Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах**

4. **2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах**

5. **“Ард Кредит ББСБ” ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах**

**АРД КРЕДИТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДЭГ**

2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн байранд 11:00 цагт эхэлж, 13:00 цагт дууснa.

| № | Хэлэлцэх асуудал | Хариуцах | Хугацаа |
|---|---|---|---|
| 1 | Хурлын ирц бүртгэх, ирцийг мэдээлэх | Тооллогын комиссын дарга: Ө.Бямбагэрэл (Ард секюритиз ҮЦК ХХК) | 11:00-11:15 |
| 2 | Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээх, хурлын дэг танилцуулах | Хурлын дарга: Ч.Ганзориг (Ард Кредит ББСБ ХК-ийн ТУЗ-ийн дарга) | 11:15-11:30 |
| 3 | Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах | Гүйцэтгэх захирал Г.Сүхбаатар | 11:30-11:45 |
| 4 | Компанийн 2023 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах | Грант Торнтон Аудит | 11:45-11:50 |
| 5 | Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах | ТУЗ-ийн дарга Ч.Ганзориг | 11:50-12:00 |
| 6 | 2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах | Санхүү эрхэлсэн захирал Д.Лхагва-Очир | 12:00-12:05 |
| 7 | Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруула:<br>- Зарласан хувьцааны тоо ширхэгийг нэмэлт хувьцаа гаргасантай холбоотойгоор шинэчлэн бүртгэх,<br>- Бусад өөрчлөлт | Гүйцэтгэх захирал Г.Сүхбаатар | 12:05-12:30 |
| 8 | Хэлэлцэх асуудлуудтай холбоотой асуулт, хариулт | Хурлын дарга: Ч.Ганзориг (Ард Кредит ББСБ ХК-ийн ТУЗ-ийн дарга) | 12:30-12:45 |
| 9 | Санал хураах | Хурлын дарга<br>Тооллогын комиссын дарга | 12:45-12:50 |
| 10 | Санал хураалтын дүнг нэгтгэн танилцуулах, Тооллогын комиссын тогтоолыг батлуулах | Тооллогын комиссын дарга: Ө.Бямбагэрэл (Ард секюритиз ҮЦК ХХК) | 12:50-13:00 |
| 11 | Хурлаас гарсан шийдвэрийг хурлын дарга танилцуулж батлуулах, хурлыг хаах | Хурлын дарга: Ч.Ганзориг (Ард Кредит ББСБ ХК-ийн ТУЗ-ийн дарга) | 13:00-13:10 |

**Тооллогын комиссын бүрэлдэхүүн:**

Тооллогын комиссын дарга: Ө.Бямбагэрэл (Ард секюритиз ҮЦК ХХК-ийн Хуулийн зөвлөх)

Тооллогын комиссын гишүүн: Т.Батбаяр (Ард секюритиз ҮЦК ХХК-ийн Дилер)

Тооллогын комиссын гишүүн: Ө.Март (Ард Кредит ББСБ ХК-ийн Дотоод аудитор)

# ХУРЛЫН ЗАР

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2024 оны 3 сарын 13-ны өдрийн
2024/14 тоот тогтоолын Хавсралт №3

## АРД КРЕДИТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Ард Кредит ББСБ ХК нь Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулахаар боллоо. Хувьцаа эзэмшигч та хурлын өдөр Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн байранд хүрэлцэн ирж хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаа оролцоно уу.

**Компанийн оноосон нэр:** Ард Кредит ББСБ ХК

Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 2024/14 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах тухай зарлаж байна.

**Хурал хуралдуулах өдөр, цаг, байршил:** 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 11:00 цагт Сэнтрал тауэр барилгын 17 давхарт Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн байранд хуралдана.

**Хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Үүнд:**

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. Компанийн 2023 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
3. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
4. 2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах;
5. Ард Кредит ББСБ ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;

**Бүртгэлийн өдөр: 2024 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр**

**Хуралд бэлтгэх явцад Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт:**

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан;
2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлт;
3. Ард Кредит ББСБ ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
4. Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх, саналын хуудасны загвар;
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;
6. Хувьцаа эзэмшигчийн хурлын тогтоолын төсөл;

Хувьцаа эзэмшигчид та бүхэн 2024 оны 4 дүгээр сарын 05-ны өдрөөс 2024 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн хооронд өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанид хандан, эсхүл www.ardcredit.com цахим хуудсаар болон компанийн байранд биечлэн ирж танилцах боломжтой.

Хувьцаа эзэмшигч та өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол 2024 оны 4 дүгээр сарын 23-ны өдрөөс өмнө ажлын өдрүүдэд 09:00-18:00 цагийн хооронд Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Сүхбаатарын талбай 2, Сэнтрал Тауэр барилгын 17 давхарт "Ард Санхүүгийн нэгдэл" ХК-ийн байранд ирж, санал авах хэвлэмэл хуудсаар, Ард Апп дахь санал авах хуудсаар дамжуулан урьдчилан саналаа өгнө үү.

Хурлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг компанийн байранд болон хурал зохион байгуулах комиссын утсаар холбогдон авна уу.

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Сүхбаатарын талбай 2, Сэнтрал Тауэр барилгын 17 давхарт
Утас: 77003322

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Санхүүгийн Зохицуулах Хорооны
2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн
377 дугаар тогтоолоор батласан
"Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн
хурлын зар хүргэх журам"-ын нэгдүгээр Хавсралт

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

| | |
|---|---|
| Компанийн нэр | Ард Кредит ББСБ ХК |
| Хаяг | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай-2, Сэнтрал тауэр барилгын 13 давхар, 1313 тоот |
| Хурал хуралдах өдөр, цаг | 2022 оны 4 сарын 25-ны өдөр, 11:00 цаг |
| Хурал хуралдах газар /хаяг, байршил/ | Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн байр /Сэнтрал тауэр барилга 17 давхарт, |
| Хурлын төрөл | Ээлжит |
| Хурал зарлагч | Төлөөлөн удирдах зөвлөл |
| Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо | 2024 оны 3 сарын 13-ны өдөр |
| Олон нийтэд зарлах огноо | 2024 оны 3 сарын 18-ны өдөр |
| Бүртгэлийн өдөр | 2024 оны 4 сарын 5-ны өдөр |
| Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо | 2024 оны 3 сарын 23-ны өдөр |
| Хүргүүлсэн огноо | 2024 оны 3 сарын 21-ний өдөр |
| Хурлын даргын нэр | Чулуун овогтой Ганзориг |
| Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэрс | Комиссын дарга: О.Бямбагэрэл<br>Комиссын гишүүн: Т.Батбаяр<br>Комиссын гишүүн: Ө.Март |
| Баримт, бичгийн жагсаалт | Хавсралтаар |
| Баримт, бичгийн хуудасны тоо | ....... |

Хурал зохион байгуулах комиссын дарга

........................ /Г.Сүхбаатар/

2024 оны 3 сарын 13

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах
2. Компанийн 2023 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах
3. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
4. 2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах
5. “Ард Кредит ББСБ” ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах



# Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан

# **МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН** /аудитлагдаагүй/

Санхүүгийн зохицуулах хорооны
2008 оны 03-р тогтоолын хавсралт 1
СТ-3

## ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

"АРДКРЕДИТ ББСБ" ХК
(Аж ахуйн нэгж, байгууллагын нэр )

2023 оны 12 сарын 31 өдөр

/Төгрөгөөр/

| Үзүүлэлт | Хувьцаат капитал | Нэмж төлөгдсөн капитал | Дахин үнэлгээний нөөц | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| **2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл** | **2,800,000,000.00** | **5,342,622,574.04** | 7,053,406,086.82 | 0.0 | **7,409,235,812.38** | **22,605,264,473.24** |
| Бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | | - |
| **Залруулсан үлдэгдэл** | **2,800,000,000.00** | **5,342,622,574.04** | **7,053,406,086.82** | - | **7,409,235,812.38** | **22,605,264,473.24** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт / бууралт | | | | | | - |
| Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт / бууралт | | | (10,365,666,836.24) | | | **(10,365,666,836.24)** |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз. гарз | | | (88,868,150.96) | | 88,868,150.96 | - |
| Тайлант үеийн цэвэр ашиг | | | | | 2,059,224,326.59 | **2,059,224,326.59** |
| Ногдол ашиг | | | | | (1,259,511,916.50) | **(1,259,511,916.50)** |
| Хувьцаат капиталын өсөлт | (58,310.00) | 10,169,859.17 | | | 5,000,000,000.00 | |
| **2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл** | **2,799,941,690.00** | **5,352,792,433.21** | **(3,401,128,900.38)** | - | **13,297,816,373.43** | **18,049,421,596.26** |
| Бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | | - |
| **Залруулсан үлдэгдэл** | **2,799,941,690.00** | **5,352,792,433.21** | **(3,401,128,900.38)** | - | **13,297,816,373.43** | **18,049,421,596.26** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт / бууралт | | | 135,380,353.10 | | | **135,380,353.10** |
| Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт / бууралт | | | (449,361,719.64) | | | **(449,361,719.64)** |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз. гарз | | | 2,546,501,504.92 | | (2,546,501,504.92) | - |
| Тайлант үеийн цэвэр ашиг | | | | | 2,655,372,436.31 | **2,655,372,436.31** |
| Ногдол ашиг | | | | | | - |
| Хувьцаат капиталын өсөлт | 58,310.00 | - | | | | **58,310.00** |
| **2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл** | **2,800,000,000.00** | **5,352,792,433.21** | **(1,168,608,762.00)** | - | **13,406,687,304.82** | **20,390,870,976.03** |

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ - (Г.ТЭЛМЭН)

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ (Х.ЦЭРЭННАДМИД)

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344 ✆ 5455567

# ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН /аудитлагдаагүй/

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**
**"АРДКРЕДИТ" БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА**

2023 оны 12 сарын 31 өдөр

| Үзүүлэлт | Өмнөх оны дүн | Тайлант оны дүн |
|---|---|---|
| ***1 Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн*** | ***(2,455,817,168.60)*** | ***1,770,717,083.14*** |
| **1.1 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого** | **130,140,881,537.38** | **160,156,274,672.00** |
| 1.1.1 Зээлийн хүүгийн орлого | 11,788,784,656.00 | 11,492,712,974.00 |
| 1.1.2 Үнэт цаасны хүүгийн орлого | 15,706.30 | 761,621.92 |
| 1.1.3 Факторингийн үйлчилгээний хүүгийн орлого | | |
| 1.1.4 Харилцах дансны хүүгийн орлого | | 52,719,230.21 |
| 1.1.5 Банкин дахь хадгаламжийн хүүгийн орлого | | |
| 1.1.6 Санхүүгийн түрээсийн орлого | | |
| 1.1.7 Гадаад валютын арилжааны орлого | 360,405,308.49 | 178,777,774.75 |
| 1.1.8 Үнэт цаасны арилжааны орлого | | |
| 1.1.9 Гадаад валютын ханшийн зөрүү | 727,167,495.69 | 969,389,122.87 |
| 1.1.10 Үнэт цаасны үнэлгээний зөрүү | | |
| 1.1.11 Итгэлцлийн үйлчилгээний орлого | 13,683,046,018.00 | 25,792,243,149.00 |
| 1.1.12 Мөнгөн гуйвуулгын орлого | 5,054,884,851.61 | 4,295,481,519.00 |
| 1.1.13 Картын үйлчилгээний орлого | | 8,847,460.70 |
| 1.1.14 Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого | | |
| 1.1.15 Санхүүгийн түрээсийн орлого | | |
| 1.1.16 Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого | 2,763,557,148.29 | 3,163,771,410.00 |
| 1.1.17 Хүүгийн орлогын буцаалт | | |
| 1.1.18 Бусад үйлчилгээний орлого | 95,763,020,353.00 | 114,201,570,409.55 |
| **1.2 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага** | **132,596,698,705.98** | **158,385,557,588.86** |
| 1.2.1 Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал | 1,227,780,958.90 | 1,446,605,618.82 |
| 1.2.2 Төслийн зээлийн санхүүжилтын хүүгийн зардал | 824,298,930.00 | 1,050,304,099.00 |
| 1.2.3 Өрийн бичгийн хүүд төлсөн мөнгө | 626,720,371.66 | 85,282,035.61 |
| 1.2.4 Хүүгийн зардлын буцаалт | | |
| 1.2.5 Үндсэн ба нэмэгдэл цалин | 795,650,822.50 | 1,056,398,063.50 |
| 1.2.6 Ажилтануудад олгосон нөхөн олговор, тэтгэмж | 4,487,049.62 | 6,728,263.00 |
| 1.2.7 Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал | 269,028,705.82 | 360,447,292.62 |
| 1.2.8 Албан томилолт, сургалтын зардал | 38,894,261.96 | 215,803,578.21 |
| 1.2.9 Ашиглалтын зардалд төлсөн мөнгө | 14,001,256.98 | 20,010,000.00 |
| 1.2.10 Шатахуун, холбоо, интернет, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө | 46,258,482.03 | 44,454,804.78 |
| 1.2.11 Бичиг хэргийн зардал, ариун цэврийн зардал | 25,947,460.00 | 55,164,229.00 |
| 1.2.12 Татвар, даатгалын төлсөн мөнгө | 966,585,981.42 | 1,241,059,867.33 |
| 1.2.13 Зар сурталчилгаанд төлсөн мөнгө | 85,516,758.91 | 166,899,183.93 |
| 1.2.14 Үнэт цаас болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбоотой гарсан мөнгө | | - |
| 1.2.15 Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан мөнгө | 20,020,879.00 | 176,433,503.34 |
| 1.2.16 Факторинг болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан мөнгө | | |
| 1.2.17 Итгэлцлийн үйлчилгээ болон түүнтэй холбогдон гарсан мөнгө | 18,290,389,358.95 | 12,286,635,053.00 |
| 1.2.18 Санхүүгийн түрээсийн үйл ажиллагаатай холбогдон гарах | | |
| 1.2.19 Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээний мөнгө | 1,134,554,362.67 | 854,684,445.00 |
| 1.2.20 Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө | 28,657,422.00 | 48,144,216.28 |
| 1.2.21 Ногдол ашгаар олгосон мөнгө | 1,160,508,417.28 | |
| 1.2.22 Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн бусад мөнгө | | |
| 1.2.23 Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө | 107,037,397,226.28 | 139,270,503,335.44 |
| ***2 Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ*** | ***527,368,327.27*** | ***424,777,632.81*** |
| **2.1 Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого** | **572,316,519.90** | **459,634,453.75** |
| 2.1.1 Үндсэн ба хөрөнгө борлуулсны орлого | | 455,000,000.00 |
| 2.1.2 Ногдол ашгийн орлого | 25,102,879.20 | 4,634,453.75 |
| 2.1.3 Хандив | | |
| 2.1.4 Бусад | 547,213,640.70 | |
| **2.2 Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага** | **44,948,192.63** | **34,856,820.94** |
| 2.2.1 Баяр ёслол, зочин төлөөлөгчийн зардал | 25,261,526.63 | 32,383,355.56 |
| 2.2.2 Торгуулийн зардал | | 572,456.00 |
| 2.2.3 Бусад | 19,686,666.00 | 1,901,009.38 |
| **3 Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **(1,928,448,841.33)** | **2,195,494,715.95** |
| **4.1 МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ** | **6,956,116,392.85** | **5,027,667,551.52** |
| **4.2 МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ** | **5,027,667,551.52** | **7,223,162,267.47** |
| | (1,928,448,841.33) | 2,195,494,715.95 |
| | 0.00 | (0.00) |

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ (Г.ТЭЛМЭН)

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ (Х.ЦЭРЭННАДМИД)

АРД КРЕДИТ ББСБ ХК
9023051344 5450567

# Компанийн 2023 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлт



## КОМПАНИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙГДСЭН ХАРААТ БУС АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ДҮГНЭЛТ

## Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлт



# КОМПАНИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТ

КРЕДИТ ББСБ

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 4 сарын 02-ны өдөр Дугаар2024/ Улаанбаатар хот

2023 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайланд дүгнэлт гаргах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх хэсэг, 80 дугаар зүйл, 96 дугаар зүйлийн 96.1 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 8 дугаар зүйлийн 8.2.5 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 4 дүгээр сарын 02-ны өдрийн .................. хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх санхүүгийн тайланд "Грант Торнтон Аудит" ХХК аудит хийж, гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.
2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай гэж дүгнэсүгэй.
3. Тогтоол батлагдсантай холбогдуулан үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж зохих шийдвэрийг гаргуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Ч.Ганзориг)-д даалгасугай.
4. 2023 оны санхүүгийн тайланг хууль тогтоомжийн дагуу зохих байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Г.Сүхбаатар)-т даалгасугай.
5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Дотоод аудитын хороонд үүрэг болгосугай.

ДАРГА Ч.ГАНЗОРИГ

# 2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр



# 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ҮР ДҮНГЭЭС НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ШИЙДВЭР

АРД КРЕДИТ ББСБ

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 03 сарын 07-ны өдөр | Дугаар 2024/08 | Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах өдрийг
өөрчлөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь хэсэг, 80 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 2024 оны 2 дугаарын сарын 14-ны өдрийн 2024/4 тоот тогтоол, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 сарын 07-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит бус хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдан зөвлөлийн 2024 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 2024/04 тоот тогтоолын 3 дугаар заалтад заасан "ногдол ашиг тараах хугацаа 2024 оны 7 дугаар сарын 04-ний өдөр" гэснийг "ногдол ашиг тараах хугацаа 2024 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр" гэж өөрчилсүгэй.
2. Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр хуваарилж, холбогдох хууль тогтоомжийн дагуу хувь хүний болон аж ахуй нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, хуваарилахтай холбоотой төлбөр тооцоог "Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв" ТӨХХК-иар зуучлуулан гүйцэтгүүлж, ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар 2024 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр тараасугай.
3. Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсугай.
4. Шийдвэртэй холбоотой мэдээллийг хууль тогтоомжид заасан хугацаанд холбогдох байгууллага болон нийтэд мэдээлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад даалгасугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох гэрээ хэлцэл байгуулж, төлбөр тооцоог хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал (Г.Тэлмэн)-д даалгасугай.
6. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын хороонд үүрэг болгосугай.

ДАРГА Ч.ГАНЗОРИГ

# Ард Кредит ББСБ ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгын төсөл



**ШИНЭЭР НЭМЭГДЭЖ БУЙ ЗААЛТУУД:**

1. 1.5 Компани нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, харилцагч, үйлчлүүлэгч, ажилтнуудаа урамшуулах зорилгоор өөрсдийн урамшууллын оноо АрдКойныг ашиглана. Энэ нь бусад хэлбэрээр урамшуулал олгохыг хориглох заалт болохгүй.

2. 2.1 Компани нь Хөрөнгө оруулагч Үндэстэнг цогцлоох эрхэм зорилготой, Бүтээлч түйвээлтээр дэлхийд манлайлагч финтек нэгдэл болох алсын хараатай ажиллана.

3. 9.6. Нэгдлийн оролцогч компанийн хувьд зайлшгүй шаардлагатай тохиолдолд АСН ХК-ийн гүйцэтгэх захирлаас нэгдлийн эрх ашигт болон зохицуулагч байгууллагын шаардлагад нийцсэн чиг үүргийг компанийн өдөр тутмын үйл ажиллагааг алдагдуулахгүй хийж гүйцэтгэж болно.

4. 9.7. Гүйцэтгэх удирдлага нь дүрмийн 9.6-т заасан чиг үүргийг гүйцэтгээгүй нь хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээх үндэслэл болохгүй.

5. 9.8. Гүйцэтгэх удирдлага нь дүрмийн 9.6-т заасан чиг үүргийг хийж гүйцэтгэсний улмаас АСН, компани болон гуравдагч этгээдэд хохирол учирсан тохиолдолд хуульд заасны дагуу АСН ХК-ийн гүйцэтгэх захирал хохирлыг хариуцна.

## КОМПАНИЙН ДҮРМИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫГ ДЭМЖИХ ЭСЭХ

**ӨМНӨ**

1. 1.4 Компанийн бэлгэдэл тэмдэг нь ARD КРЕДИТ ББСБ байх ба АРД гэсэн улаан гурван үсгээс бүрдсэн байх ба хажууд нь Кредит ББСБ гэж бичсэн байна.
2. 4.2 Компани нь өөрийн хувьцаа эзэмшигчдийн хариуцлагыг хүлээхгүй бөгөөд хувьцаа эзэмшигчид нь компанийн хариуцлагыг өөрийн эзэмшлийн хувьцааны хэмжээгээр хүлээнэ
3. 4.4 Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн 81, 82 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээнэ.
4. 6.1 Компанийн нэг бүр нь 10 (арав) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 280,000,000 (хоёр зуун наян сая) ширхэг хувьцаатай байна.
5. 6.2 Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь 2,800,000,000 (хоёр тэрбум найман зуун сая) төгрөг байх ба гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүн буюу хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн нийт хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ.

**ДАРАА**

1. 1.4 Компани нь Хүчтэй.Хамтдаа. гэсэн уриа үгтэй байх бөгөөд компанийн бэлгэдэл тэмдэг нь ARD КРЕДИТ ББСБ байх ба АРД гэсэн улаан гурван үсгээс бүрдсэн байх ба хажууд нь Кредит ББСБ гэж бичсэн байна.
2. 4.2 Компани нь өөрийн хувьцаа эзэмшигчдийн хариуцлагыг хүлээхгүй мөн хувьцаа эзэмшигчид нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ.
3. 4.4 Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн 84, 85 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээнэ.
4. 6.1 Компанийн нэг бүр нь 10 (арав) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 364,000,000 (гурван зуун жаран дөрвөн сая) ширхэг хувьцаатай байна.
5. 6.2 Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь 3,640,000,000 (гурван тэрбум зургаан зуун жаран дөрвөн сая) төгрөг байх ба гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүн буюу хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн нийт хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ.

## “АРД КРЕДИТ ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛААР ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС БӨГЛӨХ ЗААВАР

- Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт √ тэмдгийг бичнэ үү.
- Засварласан, балласан эсвэл аль нэг саналыг бөглөөгүй бол саналын хуудсыг хүчингүйд тооцно.
- Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Сүхбаатарын талбай 2, Сэнтрал тауэр барилгын 17 давхарт “Ард Санхүүгийн нэгдэл” ХК-ийн байранд ирж хурлын материалтай танилцаад санал авах хэвлэмэл хуудас, эсвэл Ард Апп дахь санал авах хуудсаар дамжуулан урьдчилан саналаа өгнө.
- Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл олгож, нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.
- Хувьцаа эзэмшигч нь хувь хүн бол саналын хуудас дээр гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол эрх бүхий этгээд гарын үсэг зурж болон хуулийн этгээдийн тэмдгийг дарж баталгаажуулсан байна



ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Ард Кредит ББСБ ХК-ийн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд өгсөн хувьцаа эзэмшигчдийн саналыг Тооллогын комиссын дарга **Ө.БЯМБАГЭРЭЛ** тоолно.

Тооллогын комиссын дарга болон гишүүн нь хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудалтай шууд холбоотой компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд биш болно.

**Овог:** Өсөхжаргал

**Нэр:** Бямбагэрэл

**Эрхэлж буй албан тушаал:** Ард Секюритиз ҮЦК ХХК-ийн Хуулийн зөвлөх, Комплаенсын мэргэжилтэн

**Ажлын туршлага:**

2022.06-2023.04 Монгол Улсын Хөгжлийн Банк түүний охин компани /ДИ БИ ЭМ Лизинг ХХК/-Хууль, хянан нийцүүлэлтийн захиргааны ажилтан

2023.05-с одоог хүртэл Ард Секюритиз ҮЦК ХХК-Хуулийн зөвлөх, комплаенсын мэргэжилтэн

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАСНЫ ЗАГВАР

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2024 оны 3 сарын 13-ны өдрийн
2024/,,,, тоот тогтоолын Хавсралт №2

**АРД КРЕДИТ ББСБ ХК**
**САНАЛ АВАХ ХУУДАС**
**(ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №3)**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: ____________________
Регистрийн дугаар:______________________________
Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн
Эзэмшиж буй хувьцааны тоо: ______________________

Энэхүү санал авах хуудсаар 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 11:00 цагт Сэнтрал Тауэр "Ард Санхүүгийн нэгдэл" ХК-ийн байранд хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

| № | Хурлаас гарах шийдвэрийн томьёолол | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түдгэлзсэн |
|---|---|---|---|---|
| 1 | Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах | ☐ | ☐ | ☐ |

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ✓ тэмдгийг бичнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Сүхбаатарын талбай 2, Сэнтраул тауэр барилгын 17 давхарт "Ард Санхүүгийн нэгдэл" ХК-ийн байранд ирж хурлын материалтай танилцаад санал авах хэвлэмэл хуудас, эсвэл Ард Апп дахь санал авах хуудсаар дамжуулан урьдчилан саналаа өгнө.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл олгож, нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.
4. Хувьцаа эзэмшигч нь хувь хүн бол саналын хуудас дээр гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол эрх бүхий этгээд гарын үсэг зурж болон хуулийн этгээдийн тэмдгийг дарж баталгаажуулсан байна

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг______________
Санал авах хуудсыг үйлдсэн 2024 оны ... сарын ... өдөр
Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй
Тооллогын комиссын дарга _________________ /...................../
Хүчингүйд тооцсон бол шалтгаан:

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2024 оны 3 сарын 13-ны өдрийн
2024/..... тоот тогтоолын Хавсралт №2

**АРД КРЕДИТ ББСБ ХК**
**САНАЛ АВАХ ХУУДАС**
**(ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №5)**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: ____________________
Регистрийн дугаар:______________________________
Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн
Эзэмшиж буй хувьцааны тоо: ______________________

Энэхүү санал авах хуудсаар 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 11:00 цагт Сэнтрал Тауэр Ард Санхүүгийн нэгдэл ХК-ийн байранд хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

| № | Хурлаас гарах шийдвэрийн томьёолол | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түдгэлзсэн |
|---|---|---|---|---|
| 1 | Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах | ☐ | ☐ | ☐ |

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ✓ тэмдгийг бичнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Сүхбаатарын талбай 2, Сэнтраул тауэр барилгын 17 давхарт "Ард Санхүүгийн нэгдэл" ХК-ийн байранд ирж хурлын материалтай танилцаад санал авах хэвлэмэл хуудас, эсвэл Ард Апп дахь санал авах хуудсаар дамжуулан урьдчилан саналаа өгнө.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл олгож, нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.
4. Хувьцаа эзэмшигч нь хувь хүн бол саналын хуудас дээр гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол эрх бүхий этгээд гарын үсэг зурж болон хуулийн этгээдийн тэмдгийг дарж баталгаажуулсан байна

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг______________
Санал авах хуудсыг үйлдсэн 2024 оны .. сарын .. өдөр
Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй
Тооллогын комиссын дарга _________________ /...................../
Хүчингүйд тооцсон бол шалтгаан:

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭРИЙН ТӨСЛҮҮД



# ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ №1

**“АРД КРЕДИТ ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

2024 оны 4 сарын 25 өдөр №1 Улаанбаатар хот

Хурлын ирцийн тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.7, 67 дугаар зүйлийн 67.3, 69 дүгээр зүйлийн 69.1, 69.2 дахь хэсэг, “Ард Кредит ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ард Кредит ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ... ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй ..... /үсгээр/ хувьцаа эзэмшигчид оролцож, нийт саналын эрх бүхий 280,000,000 ширхэг хувьцааны ..... хувь болж байгааг хуралд оролцогчдод болон хурлын даргад мэдэгдсүгэй.

2. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.2 дахь заалтыг тус тус үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны ..... хувь эзэмшдэг хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байгаа тул хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

Комиссын дарга ...............................................Ө.Бямбагэрэл

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛ – 1

КРЕДИТ ББСБ

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2024 оны 4 сарын 25-ны өдөр №2024/ Улаанбаатар хот

Компанийн 2023 оны үйл ажиллгааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ын дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.6, 7.9 дэх хэсэг, 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ард Кредит ББСБ” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн ... тогтоолоор гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрч батлагсугай.

ДАРГА Ч.ГАНЗОРИГ

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛ – 2

АRD КРЕДИТ ББСБ

*ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР*

2024 оны 4 сарын 25-ны өдөр №2024/ Улаанбаатар хот

Компанийн дүрэмд нэмэлт,
Өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.5 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг, Компанийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4.1, 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.6, 7.9 дэх хэсэг, болон 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Ард Кредит ББСБ" ХК-ийн Компанийн дүрэмд дараах нэмэлтийг оруулсугай.
   - 1.1. Компанийн дүрмийн 1.5 дахь хэсэгт "Компани нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, харилцагч, үйлчлүүлэгч, ажилтнуудаа урамшуулах зорилгоор өөрсдийн урамшууллын оноо АрдКойныг ашиглана. Энэ нь бусад хэлбэрээр урамшуулал олгохыг хориглох заалт болохгүй" гэж;
   - 1.2. Компанийн дүрмийн 2.1 дэх хэсэгт "Компани нь Хөрөнгө оруулагч Үндэстэнг цогцлоох эрхэм зорилготой, Бүтээлч түйвээлтээр дэлхийд манлайлагч финтек нэгдэл болох алсын хараатай ажиллана" гэж;
   - 1.3. Компанийн дүрмийн 9.6 дахь хэсэгт "Нэгдлийн оролцогч компанийн хувьд зайлшгүй шаардлагатай тохиолдолд АСН ХК-ийн гүйцэтгэх захирлаас нэгдлийн эрх ашигт болон зохицуулагч байгууллагын шаардлагад нийцсэн чиг үүргийг компанийн өдөр тутмын үйл ажиллагаа алдагдуулахгүй хийж гүйцэтгэж болно." гэж;
   - 1.4. Компанийн дүрмийн 9.7 дахь хэсэгт "Гүйцэтгэх удирдлага нь дүрмийн 9.6-т заасан чиг үүргийг гүйцэтгээгүй нь хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээх үндэслэл болохгүй." гэж;
   - 1.5. Компанийн дүрмийн 9.8 дахь хэсэгт "Гүйцэтгэх удирдлага нь дүрмийн 9.6-т заасан чиг үүргийг хийж гүйцэтгэсний улмаас АСН, компани болон гуравдагч этгээдэд хохирол учирсан тохиолдолд хуульд заасны дагуу АСН ХК-ийн гүйцэтгэх захирал хохирлыг хариуцна." гэж тус тус нэмэх;
2. "Ард Кредит ББСБ" ХК-ийн Компанийн дүрэмд дараах өөрчлөлтийг оруулсугай.
   - 2.1. Компанийн дүрмийн 1.4 дэх хэсэгт " Компани нь Хүчтэй Хамтдаа гэсэн уриа үгтэй байх бөгөөд компанийн бэлгэдэл тэмдэг нь АRD КРЕДИТ ББСБ байх ба АРД гэсэн улаан гурван үсгээс бүрдсэн байх ба хажууд нь Кредит ББСБ гэж бичсэн байна" гэж;
   - 2.2. Компанийн дүрмийн 4.2 дахь хэсэгт "Компани нь өөрийн хувьцаа эзэмшигчдийн хариуцлагыг хүлээхгүй мөн хувьцаа эзэмшигчид нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ." гэж;
   - 2.3. Компанийн дүрмийн 4.4 дэх хэсэгт "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн 84, 85 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээнэ." гэж;
   - 2.4. Компанийн дүрмийн 6.1 дэх хэсэгт "Компанийн нэг бүр нь 10 (арав) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 364,000,000 (гурван зуун жаран дөрвөн сая) ширхэг хувьцаатай байна." гэж;
   - 2.5. Компанийн дүрмийн 6.2 дахь хэсэгт "Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь 3,640,000,000 (гурван тэрбум зургаан зуун жаран дөрвөн сая) төгрөг байх ба гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүн буюу хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн нийт хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ." гэж тус тус өөрчлөх;
3. Энэхүү шийдвэрийн 1, 2 дахь хэсэгт заасан нэмэлт, өөрчлөлт оруулсан Компанийн дүрмийг хавсралтаар батлсугай.
4. Энэхүү шийдвэрийн хавсралтаар баталсан Компанийн дүрмийг хууль, тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх, холбогдох бусад байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг ....-д даалгасугай.
5. Энэхүү шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавихыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Ч.Ганзориг/-т даалгасугай.

ДАРГА Ч.ГАНЗОРИГ